

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

Ургамал хамгааллын цогц арга

Б.Дондов Доктор, дэд профессор УХЭШХ

2019 оны 6 сар



УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЦОГЦ АРГА ГЭЖ ЮУ ВЭ?

- Эрүүл таримал ургуулах, пестицидийн хэрэглээг багасгахын тулд төрөл бүрийн менежмент, арга барилуудыг нэгтгэсэн газар тариалангийн үйлдвэрлэл, ургамал хамгаалалд хэрэглэх экологийн арга хэмжээ
- Газар тариалангийн тогтвортой байдлыг хангахын тулд хөрс, шим тэжээл, усны менежмент
- Таримлыг ургуулах үйлдвэрлэлийн асуудлаас гадна хүнсний эрүүл ахуй, бүтээгдэхүүний чанар, түүнчлэн жижиг фермерүүдийг зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах боломжийг нэмэгдүүлэх асуудал

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЦОГЦ АРГЫН ЗОРИЛГО

- Эрүүл ургац, аюулгүй хүнс үйлдвэрлэх
- Химийн бодисын хэрэглээ нэмэгдэж буй тул байгаль орчныг хамгаалах
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн зардлыг багасгах
- Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх

Ургамал хамгааллын цогц аргын үндсэн зарчмууд

УХЦА нь тогтвортой хөдөө аж ахуйн хамгийн чухал үндэс учраас хүрээлэн буй орчин болон нийгмийн эрүүл ахуйг сайжруулах асуудлыг орхигдуулахгүйгээр аль болох арвин ургац, ашгийг нэмэгдүүлэхийн тулд фермерүүдийн арга барилыг сайжруулахад чиглэгдэнэ.

- Эрүүл таримал ургуулах
- Хортонгийн байгалийн дайсан буюу ашигтай шавьжийг хамгаалах
- Талбайг байнгын хяналт, ажиглалтанд байлгах
- Фермерүүд өөрсдөө мэргэжилтэн болох

Эрүүл таримал ургуулах

- Тухайн таримал ургамал өвчин, хортонд тэсвэрлэлт
- гэмтэл, халдварыг гэтлэн давж, өөрөө эдгэрэх хүчтэй дархлааны систем
- Чанартай үр, үрийн материал, өвчин, хортонд тэсвэртэй сайн чанарын таримлын сорт
- шим тэжээлийн бодисын хэрэгцээг тэнцвэртэй хангах, зөв тохирсон үйлдвэрлэлийн менежмент



Ашигтай шавьжийг хамгаалах

- паразит болон махчин шавьжууд нь таримлыг сүйтгэгч хортон шавьж, өвчин тээгч шавьжуудыг идэж тоо хэмжээг нь хянаж байдаг учраас байгальдаа ашигтай гэж хүлээн зөвшөөрөгдөж, эдгээр “байгалийн дайснууд” нь “фермерүүдийн найз” байх бөгөөд талбайд ч тэд байгалийнхаа жамаар байдаг.



Таримлыг тогтмол хянах

- хөрс, ус, хог ургамал, мөн температур, нарны гэрэл, чийг гэх мэтийн цаг уурын нөхцөл
- цаг уурын болон бусад хүчин зүйлүүдийн өөрчлөлтийн нөлөөгөөр ургамлын физиологи, морфологийн өөрчлөлт
- Өвчин, хортон шавьж, хог ургамал
- Таримлын хөгжлийн үе шат

Фермерүүд шинжээчид, мэргэжилтэн болох

- фермерүүд өөрсдийн талбайгаа мэддэг мэргэжилтэн, шинжээч болж, өөрсдийгөө үнэлсэн цагт л зөвхөн хэрэгжих боломжтой
- тусдаа буюу бүлгийн түвшинд фермерүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх замаар туршлагатай мэргэжилтэн, шинжээч болоход шаардлагатай ур чадварыг нь хөгжүүлэх

УХЦА - Эрүүл таримал-тогтвортой хөдөө аж ахуй



- эрүүл, чанартай үр



- Сортын онцлог



- Эрүүл хөрс



- Тариалах технологи



- Ээлжлэн тариалалтын систем



- Бордооны хэрэглээ, усалгаа



- Пестицидийн сонголт, хэрэглээ



- Талбайн ажиглалт, хяналт



- Хураалтын технологи



- Хадгалалтын технологи

УХЦА-ФТС-ыг хэрэглэх зарчмууд

- Фермерийн аж ахуй эрхэлнэ гэдэг нь зөв шийдвэрийг гаргах чадвар гэж ойлгож болно жишээлбэл:
 - Ямар таримал тариалах
 - Ямар сорт тариалах
 - Яаж ургуулах
 - Хэдий хэмжээний хөрөнгө зарцуулах,
 - Ямар арга ажиллагаагаар хандах гэх мэт ---



Тиймээс фермерийн аж ахуйн амжилт хамгийн зөв шийдвэрийг олж гаргахаас хамаарч байна

Суралцах замаар нээлт хийх

Бид **сонсож** байвал, заримыг **нь тогтоодог**

Харж байвал, бид **илүү ихийг тогтоодог**

Хийж байвал бид, бараг **ихэнхийг нь тогтоодог**

Харин бид **шинэ нээлт хийвэл**, түүнийгээ **хэзээ ч мартдаггүй.**



**Анхаарал тавьсанд
баярлалаа!**